

**“ТЭЭВЭР ДАРХАН” ХК**

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**Дархан-Уул аймаг  
2024 он**

2. Үнэлгээний нэгдсэн дүн

2024.05.01

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10		83,3
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, гэдгээрийн чиг үүрэг	10	8		80
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5		83,3
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		100
5	Эрсдэлийн удирдлага	8	6		75
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6		100
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7		87,5
8	Компанийн соёл	6	6		100
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9		90
	<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>63</b>		<b>87,5%</b>

4. Үнэлгээний асуулга

“ТЭЭВЭР ДАРХАН” ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана.</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	Журмын дагуу ажиллаж байгаа	ТУЗ-ийн 2022 оны 06 сарын 15-ны 01 дугаар тогтоолоор баталсан “ТУЗ-ийн үйл ажиллагааны журамаар зохицуулдаг.	2	100
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны 01 дугаар тогтоолоор баталсан ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журамаар зохицуулдаг.	1	50
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж,</i>	Ажиллаж байгаа	ТУЗ-гишүүдийн мэдээлэл, эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон хувь хэмжээ, жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж ажиллаж байгаа.	1	50



	цахим хуудсандаа байршуулна.				
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн 2022 оны 06 дугаар сарын 15-ны 02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг байгуулан ажилладаг.	2	100
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ийн гишүүдийг шаардлагатай мэдээллээр ханган, компанийн засаглалын сургалтанд хамруулсан.	2	100
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Биелүүлж ажилладаг	ТУЗ-ийн үйл ажиллагааны болон нарийн бичгийн даргын ажиллах журмын дагуу хариуцлага хүлээдэг.	2	100
ДҮН					
<b>ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</b> ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Биелүүлж ажилладаг.	Компанийн дүрмээр ТУЗ нь 1/3-с дээш хараат бус гишүүнтэй байхаар зохицуулсан. Одоогоор ТУЗ 9 гишүүнтэй, үүний 3 нь хараат бус гишүүний үүрэг гүйцэтгэж байна.	2	100
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн. Аудитын хорооны үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны болон Аудитын хорооны журмаар зохицуулдаг.	1	50
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд ердийн гишүүн. Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааг тухайлан зохицуулсан журамтай. Бодлогын баримт бичигтэй болсон.	2	100

	<i>дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гэгцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>				
10	<i>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</i>	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга биш бөгөөд ердийн гишүүн. Нэр дэвшүүлэх хороо үйл ажиллагааны журамтай мөрдөж ажиллаж байна. Залгамж халааны бодлогын баримт бичигтэй болно.	1	50
11	<i>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</i>		Компанийн ТУЗ нь байнгын болон түр хороо байх шаардлаггүй гэж үзэж байна.	2	100
ДҮН					
<b>ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ</b> ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	<i>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Биелүүлж ажилладаг.	Компани нь үйл ажиллагаа санхүүгийн тайланг улирал, хагас жил болон жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайланг ХЭ, ТУЗ-д тухай бүр мэдээлж ажилладаг.	2	100
13	<i>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.		1	50
14	<i>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>	Биелүүлж ажилладаг.	Компанийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар хянуулан дүгнэлт гаргуулж ХЭ, ТУЗ-д тухай бүр тайлагнадаг. Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хугацаанд нь илгээдэг.	2	100
ДҮН					
<b>ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</b> ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					



15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг	Аудитын байгууллагын аудитлагдсан санхүүгийн тайланд дүгнэлт өгч ажилладаг.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Биелүүлж ажилладаг.	Хөндлөнгийн аудитын аудитлагдсан тайлан дүгнэлтийг хэлэлцэж, шаардлагатай бол нэмэлт мэдээллүүдийг авч ажилладаг.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Биелүүлж ажилладаг.	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд зохих мэдээллийг тусгаж, өөрийн болон МХБ-ийн цахим хуудсаар дамжуулж мэдээллэж ажилладаг.	2	100
ДҮН					
<b>ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</b>					
<b>ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</b>					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Компани нь дотооддоо ХАБ-ын эрсдэлийн үнэлгээг тухай бүр хийж, тодорхой ажил зохиож ажилладаг.	2	100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага нь тухай бүр эрсдэлийг үнэлэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.	1	50
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн	Биелүүлж ажилладаг.	Компани дотооддоо өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлүүд болон эрсдэлийн удирдлагын талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэг.	2	100

	нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.		Үйл ажиллагааны тайланд тусгаж ажиллана		
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Цаашид хэрэгжүүлнэ.		1	50
ДҮН					
<b>ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ</b> Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлолт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Биелүүлж ажилладаг.	ХЭХ-аас Компанийн ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хэлэлцэж баталдаг.	2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Биелүүлж ажилладаг.	Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөнд ажлын байр, албан тушаалын нэршил, бүтэц зохион байгуулалт, ажиллах хүчний тоо, тэдгээрийн цалин урамшууллыг нэг бүрчлэн тогтоож, мөрдүүлж ажилладаг	2	100
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Биелүүлж ажилладаг.	Компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөөнд тусгаж, Гүйцэтгэх удирдлагатай тусгайлан гэрээ байгуулж ажилладаг.	2	100
ДҮН					
<b>ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ</b> Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	ТУЗ-с баталсан журмууд болон компанийн дотоод журмууд нь оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байдаг.	2	100
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Биелүүлж ажилладаг.	Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан мэдээ, мэдээллийг дэлгэрэнгүй тайлагнаж ажилладаг.	2	100



27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэсэгчлэн ажилладаг	Компанийн вэб сайтыг хөгжүүлж, мэдээ мэдээллийг тайлагнаж ажиллана.	1	50
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн ажилтнуудын санал хүсэлт өгөх, гомдлыг хүлээн дор бүр нь шийдвэрлэж ажилладаг бөгөөд компанийн дотоод журмын дагуу нийгмийн асуудлыг шийдэж ажилладаг.	2	100
ДҮН					
<b>НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>					
<b>ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b>					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Биелүүлж ажилладаг.	Компанийн ёс зүйн дүрмийг баримтлан ажилладаг.	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	Биелүүлж ажилладаг.	Холбогдох хууль журам дүрмийг баримтлан ажилладаг.	2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн ёс зүйн дүрэм болон компанийн дотоод журам бусад журмаар зохицуулдаг.	2	100
ДҮН					
<b>ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>					
<b>Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана</b>					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Хэсэгчлэн биелүүлж ажилладаг.	Компани өөрийн цахим хуудсаар үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг хүргэж ажиллана.	1	50
33	9.2. Компани хоронго оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	Компанийн E-mail ээр дамжуулан мэдээлэл хүргэж солилцож ажилладаг. Цаашид цахим хуудсыг хөгжүүлнэ.	2	100

34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Биелүүлж ажилладаг.	Жил бүрийн тайлан аудитлагдсаны дараа ТУЗ, ХЭзэмшигчдэд тайлангаа тавьж мэдээллийг өгч ажилладаг.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Биелүүлж ажилладаг.	Компанийн үйл ажиллагааны чиглэл, дүрмийн өөрчлөлт, нэмж хувьцаа гаргах зэрэг өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлуудыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зорчигдохөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зорчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Биелүүлж ажилладаг.	Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд ТУЗ-р хэлэлцүүлэх сонирхлын зөрчилгүй болон хараат бус гишүүдийн саналаар баталгаажуулан ажилладаг.	2	100
ДҮН					
НЭГДСЭН ДҮН					

Тайлан бэлтгэсэн:

ТУЗ-ийн НБД

Э.Жавхлантөгс

Тайланг хянаж баталсан:

ТУЗ-ийн дарга:

Ж.Очирсүх

